



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/34

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Д.Лхагвасүрэнгийн ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/132 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 2 дахь заалтаар иргэн Гүр овгийн Дамбын Лхагвасүрэн (РЮ58040231)-д "Худалдаа, үйлчилгээний зориулалттай"-гаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 7 дугаар 12-06 тоотод байршилтай 6712013049 нэгж талбарын дугаартай 1500м² газрын зориулалтыг өөрчилж, "Гэр, орон сууцны хашааны газар"-ын зориулалттай болгон үлдсэн 32 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Дамбын Лхагвасүрэн (РЮ58040231)-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

